



1. Танилцуулга

Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ОУХБ)-ын тооцоолсноор дэлхий даяар 20.9 сая хүн албадан хөдөлмөр эрхэлж байна. Эдгээрээс 18.7 сая буюу 90 хувь нь хувийн хэвшлийн байгууллага, хувь хүний эрхшээлд хөдөлмөрлөж, бэлгийн мөлжлөгт өртөж байгаа бол үлдсэн 2.2 сая буюу 10 хувь нь төрийн албадлагаар хөдөлмөр эрхэлж байна.¹

Албадан хөдөлмөр нь юуны өмнө хувь хүний эрх чөлөө, эрхэм чанарыг үгүйсгэж байгаагаараа хүний үндсэн эрхийн зөрчил юм. Энэ нь ядуурлын үндсэн шалтгаан, эдийн засгийн хөгжилд тулгарч буй саад тогтор билээ.

Дэлхий даяар албадан хөдөлмөр нь хувийн хэвшилд жил бүр 150 тэрбум ам.долларын хууль бус ашиг орлого авчирдаг. Албадан хөдөлмөр эрхэлсний улмаас ажилчдад төлөгдөөгүй цалин хөлсний нийт хэмжээг жил тутамд 19.6 тэрбум ам.доллар хэмээн тооцоолсон байна (Үүнд арилжааны шинжтэй бэлгийн мөлжлөгийн хохирогчдыг оролцуулж тооцоогүй болно).² Албадан хөдөлмөр нь компани, бизнесийн байгууллагуудын хооронд шударга бус өрсөлдөөн бий болгож, татвар, нийгмийн даатгалын орлогыг бууруулж байдаг. Төр татвар, нийгмийн даатгалын орлогоо бүрдүүлж чадахгүйгээс гадна, албадан хөдөлмөрийн хохирогчид хийсэн ажилдаа тохирох хөлс, төлбөр авч чаддаггүй. Үүний улмаас хэрэглээ, татварын орлогоос хуримтлагдах ёстой нэмэлт орлого бүрдүүлэх боломжгүй болдог.

Албадан хөдөлмөрийн асуудал олон улсын анхаарлын төвд хэвээр байна. Дэлхийн ханган нийлүүлэлтийн сүлжээнд албадан хөдөлмөр нэвтэрч, албадан хөдөлмөр ашиглан үйлдвэрлэсэн байж болзошгүй бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлох шаардлага улам бүр нэмэгдэж байна. Албадан хөдөлмөрийг шууд болон шууд бусаар ашиглах нь худалдаа, бизнест сөрөг нөлөөтэй. Монгол Улс нь Европын Холбоо(ЕХ)-ны Худалдааны хөнгөлөлтийн ерөнхий систем(GSP+)-д хамрагддаг бөгөөд энэхүү худалдааны хөнгөлөлт, урамшууллыг

цаашид үргэлжлүүлэхийн тулд олон улсын гэрээ конвенц, түүний дотор албадан хөдөлмөрийн тухай конвенцийг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай.

Жишээ: Узбекистан

Төв Азийн орнуудаас Узбекистанд төрийн оролцоотойгоор насанд хүрэгч болон хүүхдүүдээр хөвөнгийн салбарт албадан хөдөлмөр эрхлүүлж байна. ОУХБ-ын Конвенц, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах Шинжээчдийн хорооноос (цаашид Шинжээчдийн хороо гэх) уг нөхцөл байдлын талаар удаа дараа сануулга өгсний дараа Олон улсын хөдөлмөрийн бага хурлын үеэр Засгийн газар, ажилтан, ажил олгогчдын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг өрнүүлжээ.³ Нэхмэлийн салбар нь даяаршиж, олон улсын түвшинд нийлүүлэлтийн сүлжээ үүсэх түвшинд очсон тул энэ салбарт албадан хөдөлмөрийг ашиглаж байгаа нь олон улсын анхаарлыг татаж буй асуудалд зүй ёсоор тооцогдоно. Үүний улмаас Европын парламент Европын Холбоо, Узбекистан улсын хооронд байгуулж буй Хоёр талт худалдааны гэрээнд гарын үсэг зурахаа хойшлуулаад байна.⁴ Саяхан ОУХБ-ын Шинжээчдийн хороо нь Узбекистан улсаас ирүүлсэн **Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай 1999 оны 182-р конвенцийн** хэрэгжилтийн тайланд Засгийн газрын зүгээс ургац хураалтын үеэр хүүхдийн хөдөлмөр ашиглахыг зогсоох талаар авч буй арга хэмжээг “анхааралтайгаар”⁵ тэмдэглэж авсан байна. Түүнчлэн **Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105-р конвенцийн** хэрэгжилтэнд ажиглалт хийгээд, хөвөн хураахад насанд хүрэгчдийг албадан хөдөлмөрлүүлэхээс сэргийлэх, хамгаалалтын арга хэмжээ авах, эрсдлийг бууруулах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай болохыг тэмдэглэлсэн байна.⁶

Дундаж орлоготой боловч эдийн засгийн өсөлт нь буурч буй Монгол улсын хувьд албадан хөдөлмөрийг устгах, түүнээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа нэмэгдүүлж, үр дүнг хүртэх нь чухал юм. Тогвортой хөгжлийн 8 дахь зорилт буюу Зохистой хөдөлмөр, эдийн



засгийн хөгжлийг дэмжих зорилтын нэг хүрэх үр дүн нь 2030 он гэхэд албадан хөдөлмөрийг дэлхий нийтээр усгахад чиглэж байна.

Монгол Улсын 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн хуулийн 7 дугаар зүйлд албадан хөдөлмөрийг хориглосон байдаг.⁷ Мөн 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн **13.13-т Албадан хөдөлмөрлүүлэхийг гэмт хэрэгт тооцож, торгох, эсхүл найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ. Энэхүү хууль 2016 оны есдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.**

2. Албадан хөдөлмөр гэж юу вэ?

Монгол Улс ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29-р конвенцийг 2005 онд соёрхон баталсан бөгөөд үүнд албадан хөдөлмөрийг “ямар нэг торгууль шийтгэл ногдуулахаар заналхийлж аливаа иргэнээс өөрийгөө сайн дураар санал болгоогүй байхад шаардах аливаа ажил, үйлчилгээ” хэмээн тодорхойлсон байдаг.

Учирч болзошгүй аюул заналхийлэл нь бие махбодь, сэтгэл санаа, санхүү болон бусад хэлбэрээр илэрч болох бөгөөд цалин хөлс олгохгүй байх, хөдөлгөөнийг хязгаарлах, бие махбодийн хүчирхийлэл хэрэглэх, хувь хүний эрх, боломжийг хясан боогдуулах, ажлын муу нөхцөлд шилжүүлэх болон хууль бус цагаачлагчдыг холбогдох байгууллагуудад мэдээлэх зэрэг олон арга хэлбэрээр илэрдэг.

Түүнчлэн, албадан хөдөлмөрийг сайн дурын үндсэн дээр ажиллахгүй байх, дарамт шахалт үзүүлэх, хуурч мэхлэх зэрэг шинжээр тодорхойлох нь хэт хязгаарлагдмал бөгөөд нарийн тодорхойлохын тулд илүү өргөн хүрээнд авч үзэхийг шаарддаг. Тухайлбал, өрөөр барьцаалах, ажилтны бичиг баримтыг барьцаалах зэрэг бусад хэлбэр хамаарна. Эдгээр нөхцөл нь ажилд ороход (хохилогч өөрийн хүсэл зоригийн эсрэг ажиллах), эсвэл явцын дунд (хохилогч ажлаасаа гарч чадахгүй, эсвэл тодорхой хугацаанд цалин, хангамж хүртэж чадахгүй байх) үүсч болно.

Тухайн ажлын мөн чанар нь бус, харин түүнийг гүйцэтгэж, гүйцэтгүүлж буй хүмүүсийн хоорондын харилцаа албадан хөдөлмөрийг бий болгодог. Түүнчлэн дотоодын хууль тогтоомжийн дагуу хууль ёсны гэж үзэх ердийн

ажил үүргийг зөвшөөрөлгүйгээр, эсвэл шийтгэлээр сүрдүүлж гүйцэтгүүлсэн бол албадан хөдөлмөрт тооцно. Албадан хөдөлмөрийг хөдөлмөрийн гэрээ байгуулсан, хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд орсон, цалин хөлсийг бүрэн ба хэсэгчлэн төлсөн эсэхээс үл хамааран өргөн хүрээнд ойлгох хэрэгтэй.

Нийгмийн тодорхой бүлгийн хүмүүс албадан хөдөлмөрт өртөх өндөр эрсдэлтэй байдаг. Тухайлбал, цагаач ажилчид тээвэр, хоол хүнс, орон байрны төлбөрийн улмаас өрийн барьцаанд орох нь олонтаа. Ялангуяа хууль бус цагаачид илүү эмзэг байх бөгөөд тэдний цагаачлалын статус нь айлган сүрдүүлэх, нуугдах, мөлжлөгт өртөхөд хүргэдэг.

Монгол дахь цагаач ажилчдад тулгарч буй асуудлууд

Монгол Улсын Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль(2001)-д цагаач ажилчдыг хамгаалах тухай хэд хэдэн заалт тусгасан байдаг. 2011 оны байдлаар Монгол Улсад 200,000 орчим хятад цагаач ажилтан ажиллаж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлснээр БНХАУ-ын хөдөлмөрт зуучлах байгууллагын шугамаар тус улсад жуулчны визээр орж ирсэн 84 хүний паспортыг орж ирэнгүүт нь хурааж, хэд хэдэн компанид "худалдсан" байна. Ийм байдлаар хэдэн арван мянган хятад иргэд ажиллаж байна. Түүнчлэн, Хойд Солонгосын зарим цагаач ажилчид уул уурхай, хүнд хөнгөн үйлдвэр, нийтийн ахуйн үйлчилгээ, зам тээвэр, барилга, эрүүл мэндийн салбарт албадан хөдөлмөртэй дүйцэхүйц нөхцөлд ажил эрхэлдэг байна. Тэднийг ажлаас гарахыг хориглож, цалин хөлсийг Хойд Солонгосын холбогдох байгууллагад шууд шилжүүлдэг хэмээн мэдээлсэн байна^{8,9}.

Монгол Улс 2005 онд соёрхон баталсан 105 дугаар конвенцийн хувьд дараах агуулгаар албадан хөдөлмөрийг хориглосон байна:

- Улс төрийн дарамт шахалт үзүүлэх эсвэл засан хүмүүжүүлэх хэрэгсэл болгох;
- Улс төрийн үзэл бодол, түүнийгээ илэрхийлснийх нь төлөө шийтгэн цээрлүүлэх;
- Эдийн засгийн хөгжлийг түргэтгэх зорилгоор дайчлан хөдөлмөрлүүлэх;
- Хөдөлмөрийг сахилга бат сахиулах арга хэмжээ болгох;

- Ажил хаялтад оролцсоны төлөө шийтгэх;
- Иргэдийг арьс өнгө, нийгмийн байдал, яс үндэс, шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхах зэрэг болно.

Сайн дурын бус, шийтгэл хүлээлгэхүйц шинж бүхий зарим хөдөлмөрийг 29 дүгээр конвенцийн албадан хөдөлмөрийн тодорхойлолтоос тусгайлан хассан байдаг. Үүнд:

- Заавал гүйцэтгэх цэргийн алба (зөвхөн цэргийн шинжтэй ажил гүйцэтгэх);
- Иргэний үүрэг хариуцлага, олон нийтэд үйлчлэх;
- Тодорхой нөхцөлд гүйцэтгэх ялтны хөдөлмөр (доорх тодорхойлолтоос харна уу);
- Дайн, гамшиг зэрэг хүн амыг бүхэлд нь буюу нэг хэсгийг хамарсан аюултай нөхцөл байдалд гүйцэтгэх онцгой байдлын үеийн ажил үйлчилгээ зэрэг багтана.

ОУХБ Албадан хөдөлмөрийн тухай 29, 105 дугаар конвенцийг хэрэгжүүлэхэд гарч буй тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2014 онд Албадан хөдөлмөрийн Протоколыг (цаашид 29-р Протокол гэж нэрлэх) баталсан билээ. Энэхүү протоколыг одоогоор Монгол Улс соёрхон батлаагүй байна.

29-р протоколд нутаг дэвсгэр, эрх зүйн байдлаас үл хамааран албадан хөдөлмөрийг устгах, түүнээс урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээ авах, тухайлбал, албадан хөдөлмөрт өртөж болзошгүй эмзэг бүлгийнхэн, ажил олгогчдыг сургах, хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт шалгалтыг сайжруулах, нөхөн олговор авах, эрхээ сэргээх зэрэг арга хэмжээг бүх хохирогчдод хүртээмжтэй байхаар зохион байгуулах тухай заажээ. 29-р протокол нь албадан хөдөлмөр болон хүн худалдаалах гэмт хэргийн уялдаа холбоог онцгойлон авч үзэхийн хамт албадан хөдөлмөр үйлдүүлж буй этгээдийг яллахын ач холбогдлыг мөн чухалчлан үзжээ.

3. Ялтны хөдөлмөр

29-р конвенцид заасны дагуу ялтан дараах нөхцөлд албадан хөдөлмөр эрхлэх үүрэг хүлээж болно. Үүнд:

- Эрүүгийн гэмт хэрэг үйлдсэний улмаас (захиргааны журмаар болон урьдчилан хорих шатанд бус) шүүхээс ял авч хоригдож буй;

- Төрийн эрх бүхий байгууллагын удирдлага, хяналтанд байх;
- Хувь хүн, компани, аж ахуйн нэгж, байгууллага холбоодын төлөө ажиллахгүй, тэдгээрийн байр сууцанд байрлаагүй байх зэрэг болно.

Хэдийгээр хуулийн дагуу хоригдож байгаа ч 105 дугаар конвенцид заасан зорилгоор (дээр дурдсаныг харна уу) ялтныг албадан хөдөлмөрлүүлж болохгүй. Тухайлбал, хууль бус боловч тайван замаар ажил хаялтад оролцсоны улмаас хоригдож буй хэн нэгнийг албадан хөдөлмөрлүүлж болохгүй (Гэхдээ ажил хаялтын үед эрүүгийн шинжтэй үйлдэл гарсан бол албадан хөдөлмөрийг зөвтгөх үндэслэл байдаг). Үүний нэгэн адил, хорих байгууллагаас өгсөн ажлын нормыг гүйцэтгээгүй гэсэн шалтгаанаар хөдөлмөрийн сахилга бат хангуулах зорилгоор ялтныг цээрлүүлж болохгүй.

ОУХБ-ын Шинжээчдийн хорооны дүгнэлтэд хорих байгууллага хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд ялтны гүйцэтгэж буй ажил албадан хөдөлмөр биш болохыг харуулахын тулд дараах нөхцөл шаардлагыг хангасан байх ёстой гэж тэмдэглэсэн байна. Үүнд:

- Ялтан хувийн компанид хөдөлмөр эрхлэхдээ сайн дурын үндсэн дээр хүсэлтээ гаргаж, албан ёсоор бичгээр илэрхийлсэн байх;
- Ялтны цалин хөлс, эрүүл мэнд, аюулгүй байдлын нөхцөл нь ердийн ажилчны хөдөлмөрийн нөхцөлтэй ижил төстэй байх (цалин хөлснөөс авах суутгалыг төрийн эрх бүхий байгууллагаас хянаж, ялтан ажиллахтай холбоотой гарах зардал, хохирогчдод олгох нөхөн төлбөр зэргийг суутгаж болно);
- Ялтан хөдөлмөрийн орлогоосоо худалдан авалт хийх, гэр бүлээ дэмжихэд ашиглах боломжтой байх, мөн хорих байгууллагаас суллагдсаны дараа хэрэглэх зорилгоор мөнгөн хадгаламж үүсгэх боломжтой байх;
- Ялтны хөдөлмөрт хийгдэх хөдөлмөрийн хяналт, шалгалт нь ил тод, нээлттэй байх.

Дээрх нөхцлөөр хангаснаар ялтан хөдөлмөрийн мөлжлөгт өртөөгүй, хувийн хэвшлийн компаниуд албадан хөдөлмөр ашиглаагүй, мөн хорих байгууллагаас гадна буй энгийн ажилчдад сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Монгол дахь ялтны хөдөлмөр

Одоогоор Монгол Улсад 3,281 ялтан хөдөлмөр эрхэлж байна.¹⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн (2002) 120-р зүйлд ялтны хөдөлмөр нь хөдөлмөрийн зах зээлийн хэвийн нөхцөлтэй адил байх, 121-р зүйлд ялтан гүйцэтгэсэн ажлын хэмжээ, чанарт тохирсон цалин хөлс авах ёстой хэмээн заасан байдаг. Цалин хөлсийг ялтны данс руу шууд шилжүүлж болно. Гэвч бодит амьдралд ялтан хөдөлмөр эрхлээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ч доогуур цалин хөлс авах, цалингаа бүрэн авахгүй байх (хорих байгууллагын захиргааны зардалд цалингийн ихээхэн хэсгийг суутгадаг), хувийн компанид ажилладаг талаар Хүний эрхийн үндэсний комисс болон ОУХБ-ын хийсэн судалгааны тайланд дурдсан байна.^{11, 12}

ОУХБ-ын Шинжээчдийн хорооноос ОУХБ-ын 29-р конвенцийн хэрэгжилтийн тухай гаргасан шууд хүсэлтэд тэмдэглэснээр **Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль(2000)**-д архи болон мансууруулах бодист донтсон этгээдийг албадан хөдөлмөрлүүлэх, түүнийг эмчлэхтэй холбоотой гарсан зардлыг төлүүлэх шийдвэр гаргаж болохыг шүүхэд зөвшөөрсөн байна.¹³ Гэмт хэрэгт шийтгэгдээгүй эдгээр хүмүүсээс айлган сүрдүүлэлгүйгээр сайн дураар хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг нь хэрхэн авч байгаа тухай Засгийн газар тайлбарлах шаардлагатай болно.

4. Хугацаат цэргийн хөдөлмөр

ОУХБ-ын 29-р конвенцийн хувьд заавал хаах цэргийн албаар албадан хөдөлмөр эрхлүүлэхийг хүлээн зөвшөөрөх боловч энэ нь гагцхүү цэргийн шинжтэй ажил байх ёстой гэж заажээ. Өөрөөр хэлбэл, хугацаат цэргийн алба хаагчаар цэргийн бус шинжтэй заавал гүйцэтгэх ажил хөдөлмөр эрхлүүлэхийг хориглож байгаа бөгөөд үүнийг албадан хөдөлмөрт тооцно. Үүний зэрэгцээ 29, 105 дугаар конвенцийн аль аль нь хугацаат цэргээр эдийн засгийн хөгжлийг түргэтгэх зорилгоор албадан хөдөлмөр хийлгэхийг хориглодог. Иймээс хугацаат цэргийн хөдөлмөрийг хөгжлийн зорилго, эсхүл цэргийн бус төсөлд ашиглаж болохгүй ажээ.

Хэдий тийм ч 29-р конвенцид заасны дагуу хугацаат цэргийн алба хаагчдыг “гал түймэр, үер ус, бүх нийтийг хамарсан өлсгөлөн, халдварт өвчин, тахал, газар хөдлөлт, хортон ургамал,

шавьж, амьтдын дайралт гэх мэт дайн дажин, гамшиг, аюул занал тулгарсан, эсвэл тулгарах гэж буй онцгой байдалд, өөрөөр хэлбэл, хүн ам, түүний тодорхой хэсгийн амьдрал, аюулгүй байдалд хор нөлөө учруулж болзошгүй үед цэргийн бус ажил гүйцэтгүүлэхээр дайчилж болно.

Түүнчлэн инженерийн болон ижил төстэй ангид алба хааж буй хугацаат цэргийн алба хаагчдаар цэргийн сургуулилтынх нэг хэсэг болохын хувьд зам, гүүр барих зэрэг цэргийн бус ажил гүйцэтгүүлж болно. Эдгээр цэргийн алба хаагчид нь ихэвчлэн тухайн салбартаа ажил, мэргэжлийн дадлага эзэмшсэн байдаг. Түүнчлэн, хувь хүний, улс төрийн итгэл үнэмшлийн улмаас цэргийн алба хаахаас ухамсартайгаар татгалзаж буй хүмүүст цэргийн бус ажил гүйцэтгүүлж болохыг хүлээн зөвшөөрдөг байна.

Түүнчлэн, цэргийн мэргэшсэн алба хаагчид цэргийн бус ажил гүйцэтгэж байгаа нь хугацаат цэргийн хөдөлмөрөөс ялгаатай болохыг тэмдэглэх нь зүйтэй. Тэдний хувьд энхийн цагт ажлаас гарах өргөдлийг тодорхой хугацааны өмнө өгснөөр өөрийн гүйцэтгэж буй ажил үйлчилгээг зогсоох боломжтой байдаг.

Монгол Улс дахь хугацаат цэргийн хөдөлмөр

Монгол Улсын 18-25 насны эрэгтэйчүүд цэргийн албыг заавал хаах үүрэгтэй бөгөөд өөрийн хүсэл зоригийн үүднээс татгалзах боломжгүй. 1999 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Бизнесийн үйл ажиллагаанд цэргийн анги, байгууллагыг татан оролцуулах талаар 153 тоот тогтоол гаргаж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн төсөлд цэргийн албан хаагчдыг цэргийн анги, байрлалаас гадуур гэрээний дагуу ажиллуулахыг зөвшөөрсөн байна.

ХЭҮК-ын хийсэн судалгаагаар цэргийн бус ажилд цэргийн алба хаагчдыг ажиллуулах нь нийгэмд үр ашигтай гэж үзэх хандлага нийтлэг байдаг.¹⁴ ХЭҮК, ОУХБ-ын хамтран хийсэн судалгааны дүнгээс харахад цэргийн алба хаагчдын гүйцэтгэж буй цэргийн бус ажил нь сайн дурын үндсэн дээр, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, цалин хөлс олгодог¹⁵ боловч энэ ажил нь цэргийн албаны үүргийн хүрээнд гүйцэтгэж байгаа тул албадан хөдөлмөрийн тодорхойлолтын дагуу 29, 105 дугаар конвенцийн заалттай нийцэхгүй байна. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын үйл

ажиллагааны хөтөлбөр(2012-2016)-т "сэргээн босголт, хөгжлийн үйл ажиллагаанд цэргийн алба хаагчдыг татан оролцуулах арга хэмжээ авна" хэмээн заасан зорилт, Монгол Улсын Засгийн газраас 2013 онд баталсан Цэргийн хөгжлийн хөтөлбөр нь ОУХБ-ын 29, 105-р конвенцийн үзэл санаатай нийцэхгүй байна.

5. Хүн худалдаалах гэмт хэрэг

Монгол Улс 2012 онд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг баталжээ. Энэ хуульд Хүн худалдаалах гэмт хэргийг Монгол Улсын 2008 онд нэгдэн орсон Палермогийн протоколын тодорхойлолтын дагуу "Хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төсөөтэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг нь авч ашиглах мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтандаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрөл авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг хэлнэ" хэмээн заажээ.¹⁶ Хүн худалдаалах гэмт хэргийн тухай тодорхойлолт нь Палермогийн протоколд заасан эд эрхтнийг авах, мөлжлөгийн хэлбэрүүдээс бусад асуудлаар 29 дүгээр конвенцийн тодорхойлолттой бүрэн нийцэж байна. Албадан хөдөлмөрлүүлэх болон хүн худалдаалах хэргийн хамаарлыг ОУХБ-ын 29-р конвенцид "албадан болон заавал хөдөлмөрлүүлэх зорилгоор хүнийг худалдаалахын эсрэг тодорхой арга хэмжээ авах" хэмээн зааж өгсөн байдаг.

Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэрэг

Монгол Улс 2013 онд "Тэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль"-ийг баталж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх, тэднийг хамгаалах, шаардлагатай үед авах арга хэмжээг тогтоон, 2014 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Ийнхүү эрүүгийн эрх зүйн тогтолцоонд уг асуудлаар ахиц дэвшил гарч сайжирч байгаа боловч хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн байцаах, хэрэгт холбогдуулан ял шийтгэл оноох талаарх цагдаагийн байгууллагын чадавхийн асуудал санаа зовоосон хэвээр байна. Улсын мөрдөн байцаах газрын Хүн

худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь Мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх өөр нэгжүүдтэй нэгдсэн бөгөөд улсын хэмжээнд есөн ажилтан л уг асуудлыг хариуцан ажиллаж байна.¹⁷

Монгол Улсын барилга, уул уурхайн салбарт албадан хөдөлмөрийн шинжтэйгээр гадаад иргэдийг ажиллуулах, худалдаалах, нөгөө талаас Азийн орнууд, тэр дундаа Хятад улс руу эмэгтэйчүүдийг худалдаалах тохиолдлууд гарсаар байгаа тул Монгол Улсыг хүний наймааны илгээгч орон хэмээн судалгааны тайланд дурдсан хэвээр байна. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар оролдлого чармайлт гаргасаар буй боловч уг хэргийг үйлдэгчдийг илрүүлэх, яллах байдал хязгаарлагдмал байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид түүний дотор биеэ үнэлж буй эмэгтэйчүүд, хүүхдүүд хийсэн үйлдлийнхээ төлөө баривчлагдан саатуулагдаж, ял шийтгэл хүлээсэн хэвээр байна. Мөн Хятад ажилчид визийн нөхцөл зөрчсөн шалтгаанаар Монгол Улсаас албадан гаргуулах, торгууль төлөх зэргээр гэмт хэргийн хохирогч болох төдийгүй, шийтгэгдсэн хэвээр байна.¹⁸

6. Зөвлөмж

Монгол Улс нь хүний суурь эрхийг хангаж, олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, эдийн засгийн ашиг сонирхлоо хангаж, Европын холбоотой хийж буй худалдаагаа өргөжүүлж, боломжийг нэмэгдүүлэхийн тулд албадан хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах талаар дорвитой арга хэмжээ авч, хэрэгжүүлэх нь чухал байна. Энэ хүрээнд дараах үйл ажиллагааг зөвлөж байна. Үүнд:

- ОУХБ-ын 29-р конвенцийг хэрэгжүүлэхэд албадан хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор ОУХБ-ын 29-р протоколыг соёрхон баталж, хэрэгжүүлэх;
- Цагаач ажилчид, түүний дотор хууль бус цагаач зэрэг эмзэг нөхцөл бүхий ажилчдад үйлдвэрчний эвлэлд нэгдэж, хамтын хэлэлцээр хийх, эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжих;
- Цагаач ажилчид үйлдвэрчний эвлэлд нэгдэж төлөөллөө хангуулах, гэрээний нөхцөл тодорхой, төлбөр хураамж

авахгүй байх, оролцоог хангасан хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлэх, паспорт, биеийн байцаалт баримт бичиг хурааж авахаас хамгаалах, цалин хөлсийг тогтмол, шууд төлөх баталгааг хангах, аюулгүй, зохистой орчинд амьдрах, хөдөлмөрлөх нөхцлийг хангах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, ажлаа өөрчлөх боломжийг олгох зэрэг асуудлыг Монгол Улсын Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд тусгаж, цагаач ажилчдын хамгаалалтыг сайжруулах;

- Аж ахуйн нэгж байгууллагууд, ялангуяа жижиг, дунд үйлдвэр(ЖДҮ)-ийг албан

ёсны болгох хүчин чармайлтаа нэмэгдүүлэх;

- Албадан хөдөлмөр түүний дотор хүн худалдаалах гэмт хэргийн талаарх олон улсын конвенцуудын хэрэгжилтийг хангахын тулд хөдөлмөрийн хяналтыг хэрэгжүүлэх чадавхи бэхжүүлэх;
- Нотолгоонд суурилсан бодлого боловсруулж, албадан хөдөлмөрийн талаар тогтмол судалгаа, дүн шинжилгээ хийх, шаардлагатай хөрөнгийг хуваарилах;
- Ялтан, хугацаат цэрэг, цагаач ажилчдын хөдөлмөрийн өнөөгийн практикийг дахин хянан үзэх зэрэг болно.

¹ ОУХБ: ОУХБ-ын албадан хөдөлмөрийн талаарх дэлхий нийтийн тооцоолол: *Үр дүн, арга зүй* (Женев, 2012), хуудас 13.

² http://www.ilo.org/global/about-the-ilo/newsroom/news/WCMS_243201/lang--en/index.htm

³ http://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=1000:13100:0::NO:13100:P13100_COMMENT_ID:3132643

⁴ http://www.antislavery.org/english/campaigns/cottoncrimes/forced_labour_in_uzbekistan_background.aspx

⁵ http://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=1000:13100:0::NO:13100:P13100_COMMENT_ID:3256000

⁶ http://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=1000:13100:0::NO:13100:P13100_COMMENT_ID:3256210

⁷ Хөдөлмөрийн тухай хуулийг одоогоор шинэчилсэн найруулгаар боловсруулж байна.

⁸ <http://survey.ituc-csi.org/Chinese-migrant-workers-forced.html>

⁹ <http://survey.ituc-csi.org/North-Korean-workers-exploited.html>

¹⁰ Хууль зүйн яамны мэргэжилтний өгсөн тайлбар (2015)

¹¹ ХЭҮК: *Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл* (Улаанбаатар, 2014), хуудас 34-36.

¹² ОУХБ, ХЭҮК (хийгдэж буй), *Хорих байгууллагын хөдөлмөр ба заавал гүйцэтгэх ажил: Практик судалгаа*

¹³ http://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=1000:13100:0::NO:13100:P13100_COMMENT_ID:3074509

¹⁴ ХЭҮК: *Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл* (Улаанбаатар, 2014), хуудас 33

¹⁵ ОУХБ, ХЭҮК (хийгдэж буй), *Монгол Улсын заавал хаах цэргийн алба ба хугацаат цэргийн албан хаагчийн хөдөлмөр Бодлого, практикийн судалгаа.*

¹⁶ НҮБ: Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт болох Хүмүүс ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох болон хариуцлага ноогдуулах тухай протокол (НҮБ, 2000).

¹⁷ ОУХБ: *Монгол Улс: Хууль тогтоомж ба хуулийн хэрэгжилт (Хэрэг шалгах, ял ноогдуулах болон ял эдлүүлэх ажиллагаа)* (Бангкок, ОУХБ, FLARE төслийн товч танилцуулга, 2014).

¹⁸ ОУХБ: *Монгол Улс: Хууль тогтоомж ба хуулийн хэрэгжилт (Хэрэг шалгах, ял ноогдуулах болон ял эдлүүлэх ажиллагаа)* (Бангкок, ОУХБ, FLARE төслийн товч танилцуулга, 2014).